



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 13 өдөр

Дугаар А/156

Мөрөн сум

Малын гоц халдварт шүлхий өвчний
дархлаажуулалтын ажлыг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/02 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын “Шүлхий өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтыг ажлыг зохион байгуулах тухай” 2023 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн А/87 дугаар тушаалыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг аймгийн хэмжээнд бүх үхэр, гахай, цаа бугыг хамруулан 2023 оны 4 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн 25 хоногийн хугацаанд зохион байгуулсугай.
2. Дархлаажуулалтын арга хэмжээний ажлын хэсгийг шуурхай зохион байгуулан шаардагдах ажиллах хүн хүч, шатахуун, автомашинаар ханган явц, гүйцэтгэлд нь өдөр тутмын хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.
3. Дархлаажуулалтад шаардагдах вакциныг хуваарилан олгож, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, тайлан мэдээ, акт баримтыг бүрдүүлэн холбогдох газарт хүргүүлж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Л.Ариунаа)-т үүрэг болгосугай.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газар (Б.Мөнгөн-эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2023 оны
4 дүгээр сарын 13 өдрийн А/156
захирамжийн нэгдүгээр хавсралт

ШҮЛХИЙ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ДАРХЛААЖУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ХУВААРЬ

| № | Аймаг | Сум | Олгох вакцин (мян/тун) | Хайрцаг (ширхэг) | Шил (ширхэг) |
|----|---------|----------------|---------------------------|------------------|--------------|
| 1 | Хөвсгөл | Алаг-Эрдэнэ | 28.0 | 11 | 280 |
| 2 | | Арбулаг | 29.1 | 12 | 291 |
| 3 | | Баянзүрх | 30.6 | 12 | 306 |
| 4 | | Бүрэнтогтох | 31.4 | 13 | 314 |
| 5 | | Галт | 30.4 | 12 | 304 |
| 6 | | Жаргалант | 29.0 | 11 | 290 |
| 7 | | Их-Уул | 25.4 | 10 | 254 |
| 8 | | Мөрөн | 20.1 | 12 | 201 |
| 9 | | Рашаант | 20.9 | 8 | 209 |
| 10 | | Рэнчинлүмбэ | 36.5 | 16 | 365 |
| 11 | | Тариалан | 28.5 | 11 | 285 |
| 12 | | Тосонцэнгэл | 25.0 | 10 | 250 |
| 13 | | Төмөрбулаг | 24.6 | 10 | 246 |
| 14 | | Түнэл | 34.2 | 14 | 342 |
| 15 | | Улаан-Уул | 37.2 | 15 | 372 |
| 16 | | Ханх | 25.2 | 10 | 252 |
| 17 | | Хатгал | 17.0 | 7 | 170 |
| 18 | | Цагааннуур | 9.4 | 4 | 94 |
| 19 | | Цагаан-Уул | 35.5 | 14 | 355 |
| 20 | | Цагаан-Үүр | 17.0 | 7 | 170 |
| 21 | | Цэцэрлэг | 27.7 | 11 | 277 |
| 22 | | Чандмань-өндөр | 23.6 | 9 | 236 |
| 23 | | Шинэ-Идэр | 17.4 | 7 | 174 |
| 24 | | Эрдэнэбулган | 24.4 | 9 | 244 |
| 25 | | Тавиул мал | 10.0 | | 100 |
| | | Дүн | 638.100 | 255 | 6381 |